

НИЙСЛЭЛИЙН ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН ТӨВ

НИЙСЛЭЛИЙН ЦАХИМ ХУУДСАНД БҮРТГЭГДСЭН АЛБАН ТУШААЛТАД  
ГАРГАСАН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

(2024 оны 01 дүгээр сарын 01-ээс 05 дугаар сарын 20-ыг хүртэл)

1. Шийдвэрлэсэн өргөдөл гомдлын тоо

Ангилал	Нийт		Шийдвэрлэх шатандаа байгаа						Шийдвэрлэж хариу өгсөн						
			Хугацаандаа байгаа		Хугацаа хэтэрсэн		Бүгд		Хугацаандаа шийдвэрлэсэн		Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн		Бүгд		
	1=4+7		2		3		4=2+3		5		6		7=5+6		
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	
ННЗБ бүртгэсэн	Тоо	35	100%	0	0.0%	0	0.0%	0	0.0%	35	100%	0	0.0%	35	100%
	Хувь	10.5%	10.5%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	10.6%	10.6%	0.0%	0.0%	10.5%	10.5%
1800-1200 операараас	Тоо	13	100%	0	0.0%	0	0.0%	0	0.0%	13	100%	0	0.0%	13	100%
	Хувь	3.9%	3.9%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	3.9%	3.9%	0.0%	0.0%	3.9%	3.9%
Засгийн газрын 11-11 төвөөс ирсэн	Тоо	282	100%	0	0.0%	0	0.0%	0	0.0%	280	100%	0	0.0%	282	100%
	Хувь	85.5%	85.5%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	85.5%	85.5%	0.0%	0.0%	85.4%	85.4%
Нийт	Тоо	330	100%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	330	100%	0	0.0%	330	100%
	Хувь	100%	100%	100%	0.0%	0.0%	0.0%	100%	0.0%	100%	100%	0.0%	0.0%	100%	100%

2. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хугацааны тайлан.

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа	Хоног	Цаг	Минут	Нийт өргөдөл
		0	18	50

2023 оны эхний хагас жилд 2 хоног 6 цаг 13 минутын хугацаанд шийдвэрлэсэн бол энэ жилд 0 хоног 18 цаг 50 минутад буюу богино хугацаанд шийдвэрлэсэн байгаа нь харагдаж байна.

3.Хариу өгсөн хэлбэрийн тайлан.

Д/д	Хариу өгсөн хэлбэр	Тоо
1	Программ хангамж+ Мессежээр хариу өгсөн	329
2	Программ хангамж+ Мессеж+утсаар хариу өгсөн	1

4.Шийдвэрлэсэн байдал: Иргэний талд шийдвэрлэсэн өргөдөл-202


Д/д	Ангилал	Тоо
1	Иргэний талд шийдвэрлэсэн өргөдөл	324
2	Боломжгүй тухай хариу өгсөн	6

5.Өргөдөл, гомдлын төрлийн тайлан

Д/д	Байгууллага Нийслэл	Хүсэлт		Гомдол		Талархал		Санал		Нийт
		Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	
1	2023 оны эхний хагас жил	66	18.18%	26	7.16%	270	74.38%	1	0.27%	363
2	2024 оны эхний хагас жил	35	10.6%	24	7.17%	270	81.81%	1	0.30%	330

2024 оны эхний хагас жилийн өргөдөл гомдлыг 2023 оны эхний хагас жилтэй харьцуулж дүгнэж үзэхэд хүсэлт 31-ээр буюу 88.57% буурсан, гомдол 26-аас 24 болж 2-оор буюу 8.33% буурсан харагдаж байна. Иргэдээс ирсэн гомдол нийт ирсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн 7.16% эзэлж байгаа хэвээр байна.

Иргэдээс ирсэн талархал 2023 оны эхний хагаст 74.38% байсан бол энэ онд нийт өргөдөл гомдлын 81.81% эзэлж байгаа нь 7.43%



өссөн сайн үзүүлэлттэй байна.

6.Өргөдөл, гомдлын хандалтын тайлан

Д/д	Ангилал	Өргөдөл гомдлын тоо	Өргөдөл гомдлын хувь
1	Яаралтай тусламж, үйлчилгээний тухай	221	66.77%
2	Ажлаас чөлөөлөгдөх тухай	14	4.23%
3	Ажилд орох тухай	11	3.32%
4	Нийгмийн асуудал шийдвэрлүүлэх тухай	6	1.81%
5	Ажлын сахилга хариуцлагын тухай	3	0.91%
6	Эрүүл мэндийн салбарын төрийн албан хаагчийн ёс зүйн тухай	31	6.76%
7	Хоёр дахь шатлалын эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээний тухай	4	1.21%
8	Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагааны тухай	27	8.16%
9	Өрхийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай	4	1.21%
10	Цалинтай чөлөө хүсэх тухай	2	0.60%
11	Үйлчилгээний болон бусад салбарын албан хаагчийн ёс зүйн тухай	3	0.91%
12	Нийслэлийн Засаг даргын Харьяа байгууллагын үйл ажиллагааны тухай	1	0.30%
13	Замын хөдөлгөөний зөрчлийн тухай	1	0.30%
14	Нийт өргөдөл, гомдлын дүн	330	100.00%

7. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн нэгдсэн тайлан.330 өргөдөл, гомдол, санал, хүсэлт, талархал ирсэнийг 100.00% хуулийн хугацаанд судалж, шалган шийдвэрлэсэн.

8. Зөрчлийн тоон үзүүлэлт-9. Өдөрт нь багтаан шилжүүлээгүй зөрчил.

2024 оны эхний хагас жилд Нийслэлийн цахим хуудсанд бүртгэгдсэн албан тушаалтад гаргасан 330 өргөдөл, гомдол, санал, хүсэлт ирснээс эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой гомдол, талархал, санал 295 байсан.

295-аас 24 буюу 8.13% нь гомдол, 270 нь буюу 91.86% нь дуудлагын эмч, ахлах эмч, жолооч, сувилагч нарын нэр дээр ирсэн талархлууд байсан.

Үүнээс 270 талархал 141 эмч, ахлах эмч, 103 жолооч, 2 сувилагчийн нэр дээр давхардсан тоогоор 501 хүнд түргэн шуурхай ирж сэтгэлээсээ үйлчилж тусалсанд, эмнэлэгт хүргэж өгсөн, зөв оношилсонд, зөвлөгөө өгч өвчтөний биеийн байдал сайжирсанд, амь нас аварсанд, гэрт эсэн мэнд төрүүлсэнд, угартахад цаг алдалгүй аварсанд, халуун улаан, сэтгэлээсээ үйлчилсэнд, хариуцлагатай байсанд нийт хамт ононд баярлалаа гэх мэт талархсан талархлууд байна.

Зарим талархлаас үзэхэд:

Засгийн газрын 11-11 төвөөс ирсэн талархал №1, G231228060

БЗД-ийн яаралтай тусламжийн эмч Б. Цэрмаа жолооч У.Өлзийбат нарт талархал илэрхийлмээр байна. Ажлын өндөр амжилт хүсье. БЗД-ийн 1-р хорооны иргэн Х.Нямсүрэн

Засгийн газрын 1800-1200 оператораас ирсэн талархал №2, G240103112

БЗД-ийн 22 дугаар хорооны иргэн байна. 103 яаралтай тусламжийн эмч Ч.Анужин, Д.Нямсүрэн талархал дэвшүүлж байна. Ажилдаа чин сэтгэлээсээ ханддаг, өргөсөн тангарагтаа үнэнч, түргэн шуурхай үйлчилгээтэй, харилцаа, хандлага сайтай хүнийг гэсэн халуун, дулаан сэтгэлтэй та бүхний ажил үйлсэд нь амжилт, амьдралд нь сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе./96761717/

Засгийн газрын 11-11 төвөөс ирсэн талархал №3, G240103002

Нийслэлийн Түргэн Тусламжийн 103 төвийн СХД-ийн эмч П.Сандагдорж жолооч Т.Батсүх нарт талархал дэвшүүлж байна. Эмнэлгийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлж эм тариа хийж өгч үйлчилсэнд баярлаж байна. Ажилдаа хариуцлагатай хандаж эрүүл энхийн манаанд хариуцлагатай ажиллаж хөдөлмөрлөж байгаад ажлын амжилт хүсэж эрүүл энх сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. СХД-ийн 40-р хорооны иргэн Ё.Даваабаяр

Засгийн газрын 11-11 төвөөс ирсэн талархал №4, G240103020

Нийслэлийн БГД-ийн түргэн тусламжийн 3 дугаар ээлжийн эмч Э.Бадрах, жолооч И.Ням-Эрдэнэ нарт талархал дэвшүүлж байна. Миний бие муудахад түргэн шуурхай ирж үзэн анхны тусламж үзүүлсэн явдалд баярлаж байна. Та бүхэнд ажлын өндөр амжилт хүсье. БГД-ийн 22-р хорооны иргэн Х.Саранхүү.

Засгийн газрын 11-11 төвөөс ирсэн талархал №19, G240110042

Өнөөдөр буюу 2024.01.10-ний өглөө 11:00 цагийн үед Түргэн тусламжийн 103-т дуудлага өгсөн бөгөөд дуудлагын дагуу СХД-н Түргэн тусламжийн 103-н А.Билгүүн эмч болон жолооч Ш.Очирсүх нар ирсэн. Тус эмч, жолооч хоёр нь маш түргэн шуурхай хүрэлцэн ирж эмчилгээ үйлчилгээ хийж өгөөд явсан. Сэтгэл гаргаж эмчилгээ үйлчилгээг маш сайн хийж өгсөн тус эмч, жолооч хоёртоо баярласан талархсанаа илэрхийлж байна. Цаашдын ажил амьдралд нь өндөр амжилт хүсэн ерөөж байна. БЗД-ийн 5-р хорооны иргэн Д.Ганчулуун

Засгийн газрын 11-11 төвөөс ирсэн талархал №20, G240111014

01 дүгээр сарын 01 ны өдөр манай дүү бие нь өвдөөд ЧД-ийн дүүргийн Нэгдсэн эмнэлгийн түргэний эмч Б.Бүрэнжаргал жолооч нь Ж.Наранбат нар нь хурдан шуурхай, ажилдаа чин сэтгэлээсээ ханддаг, өргөсөн тангарагтаа үнэнч, ард иргэдээ гэсэн халуун сэтгэлтэй та нартаа ажил үйлсэд нь амжилт, амьдралд нь аз жаргал сайн сайхныг хүсье. СБД-ийн 13-р хорооны иргэн А.Наранцэцэг

Засгийн газрын 11-11 төвөөс ирсэн талархал №21, G240111025

Нийслэлийн Түргэн Тусламжийн Төвийн дуудлагын эмч жолооч нарт баярласан талархсанаа илэрхийлж байна. 2024 оны 01 сарын 10-ний шөнө гараа гэмтээгээд дуудлага өгөхөд түргэн шуурхай үйлчилж гарт минь маш цэвэрхэн оёдол тавьж өвчин намдаах тариа тарьж өгсөн эмч А.Билгүүн, жолооч Ш.Очирсүх хоёрт маш их баярлаж байна. Өргөсөн тангарагтаа үнэнч байж ажилдаа чин сэтгэлээсээ хандаж байгаа та бүхэнд ажилд нь амжилт амьдралд нь аз жаргал эрүүл энхийг хүсэн ерөөе. СХД-ийн –р хорооны иргэн Л.Энхтөр

Засгийн газрын 11-11 төвөөс ирсэн талархал №41, G240126020

2024 оны 01-р сарын 22-ны шөнө Нийслэлийн түргэн тусламжийн 103 дугаарт дуудлага өгсний дагуу СХД-ийн түргэн тусламжийн 3-р ээлжийн эмч Г.Болормаа болон жолооч Г.Анхныбаяр нар түргэн шуурхай ирж эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлж нөхрийн маань амь насыг аварсан. Тус хоёр албан хаагчдаа маш их баярлаж талархаж байна. Цаашдын ажил амьдралд нь өндөр амжилт хүсэн ерөөж байна. БГД-ийн 33-р хорооны иргэн Б.Мөнхцас.

Засгийн газрын 11-11 төвөөс ирсэн талархал №42, G240126059

Нийслэлийн түргэн тусламжийн БГД-ийн эмч Э.Цогтсайхан, жолооч Д.Алтангэрэл нарт талархал дэвшүүлж байна. Тус түргэн тусламж нь манай байранд хүн үзээд явж байхад нь гуйгаад даралтаа үзүүлсэн ба миний даралт 150, 100-тай маш өндөр байсан. Даралтаа мэдэж анхны тусламж авч чадсанаа маш их баярлаж байна. Та бүхэнд ажлын өндөр амжилт хүсье. БГД-ийн 27-р хорооны иргэн Д.Мөнхцоож

Засгийн газрын 11-11 төвөөс ирсэн талархал №47, G240129153

СХД-ийн нэгдсэн эмнэлгийн 103 яаралтай түргэн тусламжийн эмч Ц.Наран-од, жолооч Ю.Батбилэг нарт талархал дэвшүүлж байна. Миний охин Д. Буяндэлгэр нь бие давхар бөгөөд гэнэт өвдөлт өгөөд 103 утсаар дуудлага өгтөл тус эмч жолооч нарыг гэрт орж иртэл төрөх болж эх үрийг эрүүл саруул эх барьж өгсөнд маш их баярлаж байна. Хариуцлагатай, ёс зүйтэй эмч, мэргэжилтнүүддээ ажил хөдөлмөрийн өндөр амжилт хүсэн ерөөж байна. Цаашид улам сайн ажиллаарай. СХД-ийн 23-р хорооны иргэн Д.Дорж

Засгийн газрын 11-11 төвөөс ирсэн талархал №62, G240205132

Зүрхний хүнд гажгийн улмаас миний охин Б.Пагмадолгор нь 40 жил шаналж байгаа бөгөөд миний охины амь насыг авран хамгаалж яаралтай тусламж үйлчилгээ цаг алдалгүй түргэн шуурхай ирж үзүүлж эмчилж байгаа 103 төвийн эмч Т.Түвшин, Э.Сурмаахорол, Ч.Өнөмөнх, Г.Тогтох, Н.Наранчимэг, жолооч Э.Зоригтсан, Л.Батмөнх, Ж.Ариунбаатар нарт маш их талархаж байна. Хариуцлагатай, ёс зүйтэй эмч, мэргэжилтнүүддээ ажил хөдөлмөрийн өндөр амжилт хүсэн ерөөж байна. Цаашид улам сайн ажиллаарай. Ээж Бямбаа

Засгийн газрын 11-11 төвөөс ирсэн талархал №73, G240208068

БГД-ийн 25 дугаар хорооны иргэн. 103 яаралтай тусламжийн эмч М.Ижилтөр, жолооч Л.Ууганбаяр нарт талархал дэвшүүлж байна. 2 сарын 05-06 шилжих шөнө 103 дуудлага өгсөн юм. Хотхон руу түргэний машин орж чадахгүй, тус эмч жолооч нар нь намайг үүрч дүүрч явсаар яаралтай тусламжийг цаг алдалгүй үзүүлж, эмнэлэгт хүргэж эмнэлгийн тусламж үйлчилгээ эмчилгээ авсанаар өнөөдрөөс дээрдэж байна. Тус эмч жолооч нартаа маш их баярлалаа. Цаашдын ажил үйлсэд нь өндөр амжилтыг хүсэн ерөөж байна. БГД-ийн 4-р хорооны иргэн Ц.Даваасүрэн.

Засгийн газрын 11-11 төвөөс ирсэн талархал №233, G240430194

2024 оны 1 дүгээр сарын 30-ны өдөр гэртээ байж байгаад угаартсан. Тухайн үед дуудлагаар ирсэн Г.Хашчулуун эмчид охины маань амь насыг аварсанд маш их баярлаж явдаг. Хүүхдүүдийг маань ЭХЭМҮТ-д хүргэж өгч яаралтай арга хэмжээ авч өгсөнд талархал илэрхийлье. Ажлын өндөр амжилт, сайн сайхан бүхнийг хүсье. СХД-ийн 34-р хорооны иргэн Ц.Нямцэцэг

Засгийн газрын 11-11 төвөөс ирсэн талархал №234, G240501036

2024.04.30-ний орой 22:00 цаг өнгөрөөд ХУД-н 12 дугаар хорооны 8-63 тоотод миний бие түргэн тусламж дуудсан. Түүний дагуу ХУД-н түргэний тусламжийн эмч Н.Тунгалаг болон жолооч Г.Булгантамир нар нь маш түргэн шуурхай хүрэлцэн ирж эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлсэн. Тус эмч жолооч хоёртоо маш их баярлаж талархаж байна. Цаашдын ажил амьдралд нь аз жаргал сайн сайхан бүхнийг хүсэн ерөөж байна. ХУД-ийн 12-р хорооны иргэн Д.Нарантуяа.

Засгийн газрын 11-11 төвөөс ирсэн талархал №255, G240510023

Нийслэлийн Түргэний Тусламжийн Төв Баянзүрх салбарын ахлах эмч А.Хулангоо эмч Г.Энхжин жолооч Т.Хувьзаяа нарт баярлаж талархсанаа илэрхийлж байна. Түргэн шуурхай үйлчилгээтэй эелдэг найрсаг харилцаатай танд болон танай хамт олонд цаашдын ажилд нь өндөр амжилт амьдралд нь сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. БЗД-ийн 5-р хорооны иргэн Д.Ууганзаяа

Засгийн газрын 11-11 төвөөс ирсэн талархал №260, G240510126

БЗД-ийн түргэн тусламжийн төвийн 1-р ээлжийн эмч М.Наранзуун, жолооч Ч.Гэрэлт-Од нарт талархал илэрхийлж байна, Маш хурдан шуурхай эмчилгээ үйлчилгээг үзүүлж, өндөр настай хүнийг харвалт өгөхөөс сэргийлж, дараагийн шатанд шилжүүлж өгсөнд маш их баярлалаа. Ажилдаа чин сэтгэлээсээ ханддаг, өргөсөн тангарагтаа үнэнч, ард иргэдээ гэсэн халуун сэтгэлтэй танд ажил үйлсэд нь амжилт, амьдралд нь аз жаргал сайн сайхныг хүсье. БЗД-ийн 43-р хорооны иргэн Л.Цэрэннямаа.

Засгийн газрын 11-11 төвөөс ирсэн талархал №261, G240513013

Нийслэлийн Түргэн Тусламжийн Төв Чингэлтэй салбарын 1 дүгээр ээлжийн эмч Б.Саруулболд жолооч А.Ганхөлөг нарт Ю.Цэгмэдийн гэр бүлээс баярлаж талархсанаа илэрхийлж байна. Түргэн шуурхай үйлчилгээтэй эелдэг найрсаг харилцаатай танд болон танай хамт олонд цаашдын ажилд нь өндөр амжилт амьдралд нь сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. СБД-ийн 11-р хорооны иргэн Ц.Оюунгэрэл

Засгийн газрын 11-11 төвөөс ирсэн талархал №262, G240513112

Нийслэлийн түргэн тусламжийн 2 дугаар ээлжийн эмч О.Бүрэнцогт, жолооч Б.Баяраа нарт талархал дэвшүүлж байна. Миний бие муудан түргэн дуудахад шуурхай ирж арга хэмжээ авч дараагийн шатлалын эмнэлэгт цаг алдалгүй хүргэж өгсөнд баярлаж байна. Та бүхний ажилд өндөр амжилт хүсье. СХД-ийн 42-р хорооны иргэн С.Балжмаа

Засгийн газрын 11-11 төвөөс ирсэн талархал №263, G240514041

Нийслэлийн түргэн тусламжийн БЗД салбарын эмч Н.Ренчинжамц, жолооч С.Алтансэлэм нарт талархал илэрхийлье. Түргэн шуурхай эмнэлгийн тусламж үзүүлж аавын минь биеийг аварсан та бүхэнд талархаж байна. Түргэн шуурхай үйлчилгээтэй, эелдэг найрсаг харилцаатай, мэргэжлийн ур чадвар сайтай, хүний төлөө сэтгэлтэй, та бүхэнд цаашдын ажил хөдөлмөрт өндөр амжилтыг хүсэн ерөөе. Даваадоржийн гэр бүлээс.

Засгийн газрын 11-11 төвөөс ирсэн талархал №264, G240514124

Нийслэлийн түргэн тусламжийн төвийн Чингэлтэй дүүргийн эмч Б.Бүрэнжаргал, эмч Сэлэнгэ жолооч Наранбат нарт талархал илэрхийлж байна. 2024 оны 5 сарын 12-оос 13-нд шилжих шөнө манай ээжийн биеийн байдал муудаж түргэн тусламж дуудсан бөгөөд маш хурдан шуурхай ирж зүрхний шигдээс болохоос аварч дараагийн шатны эмнэлэгт шилжүүлж өгсөнд маш их баярлалаа. Ажилдаа чин сэтгэлээсээ ханддаг, өргөсөн тангарагтаа үнэнч, ард иргэдээ гэсэн халуун сэтгэлтэй та бүхэнд ажил үйлсэд нь амжилт, амьдралд нь аз жаргал сайн сайхныг хүсье. Жавзандуламын гэр бүл, үр хүүхдээс. ЧД-ийн 20-р хорооны иргэн М.Болормаа

### Ирсэн 24 гомдлыг шалгаж судалсан байдал:


- Гомдлыг ангиллаар нь үзэхэд:

Засгийн газрын 1800-1200 тусгай дугаарын оператораас 1 буюу 4.16%

Засгийн газрын 11-11 төвөөс ирсэн 23 буюу 95.83% тус тус эзэлж байна.

- Гомдлыг утгаар задалж үзэхэд:

- 1) Эмнэлгийн тусламж үйлчилгээний алдаа 8 буюу 33.33%
- 2) Хүлээгдэлтэй холбоотой, иргэнд зөвлөмж дутмаг, програм шинэчлэл холбоотой 3 буюу 12.50%
- 3) Эмч эмнэлгийн ажилтны ёс зүй, хүүхдийн дуудлага хүлээн авагч нэгдсэн нэгжийн утсан харилцааны алдаа 8 буюу 33.33%
- 4) Тус төвд хамааралгүй ЦЕГ-ын харьяа МШУТөвийн 103 насанд хүрэгчдийн дуудлага хүлээн авах оператортай болон тэдний програм шинэчлэлтэй холбоотой, дуут дохиотой холбоотой, тусламж үйлчилгээний дагуу үйлчилсэн, үндэслэлгүй 5 буюу 20.83%.



Гомдлыг урьд оны мөн үетэй харьцуулахад 26 байсан бол 24 болж 2 тохиолдлоор буюу 8.33% буурсан сайн талтай, ЭТҮА 1-ээр буюу 9.09% буурсан, ёс зүйн алдаа 2 тохиолдлоор буюу 25.00% буурсан байна.

Ирсэн гомдлын дагуу эмч, эмнэлгийн ажилтанд чиглэсэн ажлын байрны болон бусад төрөлжсөн эмнэлгүүдтэй хамтран 5 сургалт, хэлэлцүүлэг 10, 3 аяныг сар бүр зохион байгуулан ажилласан. Байгууллагын ёс зүйн хэсгийн хороонд 3 гомдлыг шилжүүлж шийдвэрлэсэн.

Мөн эмч, сувилагч нарт эмнэлгийн тусламж үйлчилгээнд анхаарч ажиллах зөвлөмжийг нийтдээ 11 удаа ЧАБДХА-аас гарган судлуулж танилцуулсан. Үүнд зарим сургалт, хэлэлцүүлгээс дурдахад:

- "Хүүхдэд зонхилон тохиолдох тууралтат өвчнүүдийн ялган оношилгоо" ХӨСҮТ-ийн эмч багш Б.Даваахүү орж, 2-3-р сард хуваарь гарган ХӨСҮТ-д яаралтай тусламжид 83 эмч нар дадлага сургалтад хамрагдсан.
- "Хэвлийн хөндийн хурц өвдөлтийн үеийн оношилгоо, эмчилгээ" УНТЭ-ийн эмч Г.Өнөржаргал, 54 эмч хамрагдсан.
- "Уушгины архаг бөглөрөлтөт өвчний үеийн оношилгоо, эмчилгээ" Сонгдо эмнэлгийн эмч Н.Нария орж, 62 эмч хамрагдсан.
- "Артерын гипертензийн үеийн яаралтай тусламж, эмийн зөв сонголт, анхаарах зүйлс" Сонгдо эмнэлгийн эмч Б.Намхайнямбуу зааж, 78 эмч хамрагдсан.
- "Хууль эрх зүйн тухай ойлголт" УНТЭ-ийн хуулийн мэргэжилтэн орж, 98 эмч, жолооч бусад мэргэжилтэн хамрагдсан.
- Тусламж үйлчилгээтэй холбоотой алдаан суурилсан "Алдахаас сэргийлье" сарын аяныг зохион байгуулан Хан-Уул, Чингэлтэй салбарууд тохиолдолд суурилсан онол, дадлагын хэлэлцүүлэг, уралдаан зохион байгуулж ажилласан.
- Хэлэлцүүлэг Чанар аюулгүй байдал, дотоод хяналтын албанаас нийт 5 удаа, салбарууд 5 удаа зохион байгуулж, ээлж салбарын эмч мэргэжилтэнгүүд оролцож мэдлэгээ бататган алдаанаас сэргийлж ажиллаж байна.




- ҮЭХ-оос 4-р сарын 13-15-ны өдрүүдэд нийт байгууллагын ажилчдад "Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, ХАБ, эрүүл ахуй" сэдэвт сургалт зохион байгуулсан. 98% хамрагдсан.

- Хүүхдийн дуудлага хүлээн авах нэгдсэн нэгжтэй холбоотой алдаа, гомдол буурахгүй байсан тул 3-р сарын 15-нд хэлэлцүүлгийг зохион байгуулж, ярианы бичлэг, дүрс бичлэгийг баталгаажуулж, сонсгон, ажлын ачааллын судалгаа гарган, нийтдээ зөвлөмж 6 боловсруулан гаргаж,

ажил үйлчилгээндээ хэрэгжүүлэн ажиллаж байна

"Алдахаас сэргийлье" аяныг чанар аюулгүй байдал, дотоод хяналтын албанаас зохион байгуулж, түргэн тусламжийн төрөлт, эмнэлгийн бус нөхцөлд эндсэн 0-16 насны хүүхдийн эндэгдлийн магадлан хэлэлцүүлгийг сар бүр хийж нийт эмч нар хамрагдан сууж мэдээлэл авсан.




Байгууллагаас Пүрэв гаригийн сургалтыг зохион байгуулж, төрөлжсөн эмнэлгйн зөвлөх багшаас сургалтыг авч мэдлэг чадвараа дээшлүүлэн бататгасан.



ЭМДЕГ-ын тусламж үйлчилгээг сайжруулан Karte.mn програмд эмч нарт ДА, ЧАБДХА-аас алгоритм, стандарт удирдамж, зөвлөмж, эмнэл зүйн удирдамж, ЭМС-ын тушаал заавар, хөтөлбөрүүдийг шат дараатай оруулж, эмч нар чөлөөт цагаар нэг дор судалж танилцсан.

- Хүүхдийн дуудлага хүлээн авагч нарын ажиллах нөхцлийг сайжруулан, 9 чихэвчийг шинээр авч ажил үйлчилгээндээ хэрэглэж байна.
- ЭМХТ, ЭХЭМҮТ-ээс зохион байгуулсан "Хүүхдийн АЗВЦХ-аас сэргийлэх ба эмчлэх" багц цагийн сургалтад 10 эмч хамрагдан суусан.

ХЯНАСАН: ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ ХАРИУЦСАН  
ОРЛОГЧ ДАРГА



Б.АЙБОЛАТ

НЭГТГЭСЭН: ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ДОТООД  
ХЯНАЛТЫН АЛБАНЫ МЕНЕЖЕР

З.ЭНХЦЭЦЭГ